

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/008/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhanda@audit.gov.mn

Аудитор: Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: Gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03. 24 № 126

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чандмань сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 24,056.9 мянган төгрөгөөр тасарсан, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн,
- Үйл ажиллагааны орлого 13,685.2 мянган төгрөгөөр, бууны албан татвар 35.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 94.8 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 172,367.5 мянган төгрөгөөр тус тус тасарсан,

8225020357

- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 431,168.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон байна.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

"Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 3 орон тоо нэмэгдсэн байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 693,115.9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 600,148.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 92,967.6 мянган төгрөгөөр буюу 86.6 хувьтай биелүүлж, орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,368,462.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 61,791.6 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 793,837.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 6 зорилт, 122 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 95.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	853,505.20	552,766.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	290,334.90	263,746.60
33	АВЛАГА	252,491.50	177,717.20
35	БАРАА МАТЕРИАЛ	68,265.70	98,830.40
36	НӨӨЦИЙН БАРАА	22,413.10	12,472.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	220,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,169,636.90	1,780,513.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,169,636.90	1,780,513.70
39200	Биет хөрөнгө	1,054,665.90	1,665,855.20
39300	Биет бус хөрөнгө	114,971.00	114,658.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,023,142.10	2,333,279.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	49,002.20	168,224.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	49,002.20	168,224.50
41300	Өглөг	49,002.20	168,224.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,974,139.90	2,165,055.40
51	Засгийн газрын хувь оролцоо	1,974,139.90	2,165,055.40
51100	Засгийн газрын оруулсан капитал	210,318.00	210,318.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,644,897.90	1,840,183.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	118,924.10	114,553.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,023,142.10	2,333,279.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,128,853.00	3,077,648.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	399,070.10	596,649.90
110	Орлогын албан татвар	215,583.70	424,795.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	222,937.00	437,435.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(7,353.30)	(12,640.60)
113	Хөрөнгийн албан татвар	42,039.10	59,090.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	141,447.30	112,764.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	332,667.00	801,944.60
120	Нийтлэг татварын бус орлого	332,667.00	801,944.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,397,115.90	1,679,053.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,569,429.10	2,347,664.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,569,429.10	2,347,664.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,327,961.70	2,293,774.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,961.30	701,572.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,453.90	87,783.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	493,148.90	592,645.20
2104	Хангамж, бараа материалын зардал	88,004.40	44,240.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000.00	489,894.40
2107	Томилолт, зочны зардал	16,516.00	19,596.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,156.40	53,233.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	217,720.80	304,808.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,241,467.40	53,889.90

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	559,423.80	729,984.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	169,752.20	539,068.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	389,671.60	190,915.50

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,584,502.30	1,584,502.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,222.50	2,222.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,586,724.80	1,586,724.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(2,256.50)	(2,256.50)
9	Тайлант үеийн үр дүн	389,671.60	389,671.60
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,974,139.90	1,974,139.90
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,974,139.90	1,974,139.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,370.60	4,370.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,978,510.50	1,978,510.50
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(4,370.60)	(4,370.60)
19	Тайлант үеийн үр дүн	190,915.50	190,915.50
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,165,055.40	2,165,055.40

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,873,706.40	2,343,324.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	399,070.10	596,649.90
110	Орлогын албан татвар	215,583.70	424,795.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	222,937.00	437,435.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(7,353.30)	(12,640.60)
113	Хөрөнгийн албан татвар	42,039.10	59,090.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	141,447.30	112,764.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,548.00	5,981.20
1181	Газрын төлбөр	136,860.00	106,783.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	39.40	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,518.20	67,620.50
120	Нийтлэг татварын бус орлого	28,518.20	67,620.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,446,118.10	1,679,053.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,412,620.10	2,032,144.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,412,620.10	2,032,144.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,122,150.40	1,975,983.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,961.30	710,101.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,453.90	87,783.70

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,129.20	483,827.60
2104	Хангамж, бараа материалын зардал	40,092.20	41,780.00
2105	Нормативт зардал	5,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000.00	431,487.60
2107	Томилолт, зочны зардал	16,516.00	19,596.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	472,614.50	59,933.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,383.40	141,473.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,290,469.60	56,160.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	461,086.30	311,180.10
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	386,842.40	337,768.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	386,842.40	337,768.50
2200	Дотоод эх үүсвэрээр	386,842.40	337,768.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(386,842.40)	(337,768.50)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	74,243.90	(26,588.40)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	216,091.00	290,334.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	290,334.90	263,746.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,563,774.60	2,200,101.29	363,673.31	85.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,016,526.20	1,875,732.81	140,793.39	93.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,958,964.20	1,819,572.00	139,392.20	92.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,011.20	699,301.71	4,709.49	99.3
210101	Үндсэн цалин	702,269.20	698,734.66	3,534.54	99.5
210104	Урамшуулал	1,742.00	567.05	1,174.95	32.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,783.70	87,783.70	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	60,248.50	60,248.50	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,883.80	6,883.80	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,441.90	3,441.90	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,441.90	3,441.90	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,767.60	13,767.60	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	504,037.00	483,827.55	20,209.45	96.0
210301	Гэрэл, цахилгаан	29,350.00	26,223.45	3,126.55	89.3
210302	Түлш, халаалт	469,987.00	452,904.56	17,082.44	96.4
210303	Цэвэр, бохир ус	4,700.00	4,699.54	0.46	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	42,727.00	36,373.19	6,353.81	85.1
210401	Бичиг хэрэг	5,445.00	5,445.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	31,800.00	25,541.77	6,258.23	80.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400.00	2,304.42	95.58	96.0
210404	Ном, хэвлэл	300.00	300.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120.00	120.00	-	100.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,662.00	2,662.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	501,130.00	437,487.55	63,642.45	87.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,870.00	6,870.00	-	100.0
210604	Урсгал засвар	494,260.00	430,617.55	63,642.45	87.1
2107	Томилолт, зочны зардал	20,000.00	19,596.00	404.00	98.0
210702	Дотоод албан томилолт	20,000.00	19,596.00	404.00	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,875.30	26,879.10	43,996.20	37.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,254.30	24,304.30	42,950.00	36.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,150.00	604.80	545.20	52.6
210803	Даатгалын үйлчилгээ	330.00	-	330.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95.00	-	95.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66.00	-	66.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,480.00	1,470.00	10.00	99.3
210807	Газрын төлбөр	500.00	500.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,400.00	28,323.20	76.80	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,000.00	25,923.20	76.80	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400.00	2,400.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,562.00	56,160.81	1,401.19	97.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,562.00	56,160.81	1,401.19	97.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	46,062.00	44,689.31	1,372.69	97.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,500.00	11,471.50	28.50	99.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	451,100.90	324,368.48	126,732.42	71.9
223001	Бусад хөрөнгө	451,100.90	324,368.48	126,732.42	71.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	96,147.50	-	96,147.50	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	96,147.50	-	96,147.50	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,563,774.60	2,217,088.83	346,685.77	86.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	48,487.50	(48,487.50)	
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	48,487.50	(48,487.50)	
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,328,023.30	2,105,479.25	222,544.05	90.4
320001	Орон нутгийн төсвөөс	2,085,268.60	1,873,405.76	211,862.84	89.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	242,754.70	232,073.49	10,681.21	95.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	235,751.30	63,122.07	172,629.23	26.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,802.00	48,655.07	(44,853.07)	1279.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,012.80	14,467.00	49,545.80	22.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	167,936.50	-	167,936.50	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	167,936.54	(167,936.54)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	184,924.08	(184,924.08)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	

610001	Төсвийн байгууллага	-	-	-
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	-
620001	Удирдах ажилтан	-	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-
620004	Гэрээт ажилтан	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,311.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,311.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,811.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,800.00
210101	Үндсэн цалин	10,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,406.78
210401	Бичиг хэрэг	455.00
210402	Тээвэр, шатахуун	3,458.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,493.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,454.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,454.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,500.20
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,500.20
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19,500.20
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	189,311.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,311.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	187,816.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,495.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар залруулга хийгдээгүй.

3.2 Аудитаар залруулагдаагүй нийт 292.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 292.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн.

3.2.1 Харьяа байгууллагууд

Чандмань сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.2.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 353.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 5 алдааг залруулж, 6.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 22.3 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2.3 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 30.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 3.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 106.8 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.3 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 292.5 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

3.4 Албан шаардлага

1. Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 24.1 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 13.7 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.03 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.09 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 172.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Чандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 523.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 384.4 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 138.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй

3. 5.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Орон нутгийн төсвөөс 61.8 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн.Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 11.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу, Эрүүл мэндийн төвд 71.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Чандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
									Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Чандмань сумын Засаг даргын Тамгын газар	3	30,570.9	1	17,500.0	2	13,070.9	3	30,570.9	-	-	-	-	-	-
Чандмань сумын Орон нутгийн хөгжлийн сан	4	353,420.4	-	-	4	353,420.4	4	353,420.4	-	-	-	-	-	-
Чандмань сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	440.9	-	-	1	440.9	1	440.9	-	-	-	-	-	-
Дүн	8	384,432.2	1	17,500.0	7	366,932.2	8	384,432.2	-	-	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтийн	Хязгаарлалтын	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түвэрт	Нийт зөрчил						Үүнээс									
							ТОО		ДҮН		ТОО		ДҮН		ТОО		ДҮН		ТОО		ДҮН	
							Телбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	ТОО	ДҮН	
Чандмань сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	1	-	-	-	3	292,523.5	-	2	210,239.4	1	82,284.1	-	-	-	-					
Чандмань сумын Засаг даргын Тамгын газар	1	-	1	-	-	-	5	110,162.0	2	3,312.0	3	106,850.0	-	-	-	-						
Чандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	1	-	2	2,295.2	2	2,295.2	-	-	-	-	-	-						
Чандмань сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-						
Чандмань сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-						
Чандмань сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	1	-	3	26,187.3	2	6,157.5	2	20,029.8	-	-	-	-						
Дүн	6	-	2	-	4	-	13	431,168.0	9	9,469.5	9	339,414.4	1	82,284.1	-	-						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах					Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			
		Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан		
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	5	1	4			1			
2	ТТЗ	1	1				1			
	НИЙТ		2				2			